

МҮНС-ИЙН ВИРТУАЛЬ ЛАВЛАГААНЫ АЛБАНЫ ЖУРАМ

1. Нийтлэг үндэслэл

Виртуаль лавлагааны алба /Цаашид ВЛА гэх/ нь сэдэвчилсэн, бүх чиглэлийн мэдээллийн хайлттай холбоотой алслагдсан хэрэглэгчдийн хүсэлтийг гүйцэтгэх МҮНС-гийн онлайн лавлагаа юм. Энэхүү албыг МҮНС-ийн номзүйчид тус журмын дагуу хариуцаж ажиллуулна.

2. ВЛА-ны үүрэг

- Бүх хэрэглэгчдэд нээлттэй, үнэ төлбөргүй байна
- Хүлээн авах лавлагаанууд нь түгээмэл шинж чанарыг агуулсан байна
- Бусад номын сангийн баазан дээр гүйцэтгэгдэж чадаагүй лавлагааг гүйцэтгэхдээ анхдагч нь байх
- Лавлагааны хэв шинжээс үл шалтгаалан хурдан шуурхай гүйцэтгэх
- Ирсэн лавлагаанд заавал хариу өгөх
- Хэрэглэгчдийн оюуны эрх чөлөөг хүндэтгэн, хувийн мэдээллийн нууцыг хадгалах,
- Хандаж буй хэрэглэгчдэд тэдгээрийн нас, боловсролын түвшин, оршин суугаа газар, мөн түүнчлэн МҮНС-гийн уншигч мөн эсэхээс үл шалтгаалан үйлчлэх,

3. Хүлээн авах лавлагааны төрөл

- МҮНС-гийн сан хөмрөгт хадгалагдаж буй ном хэвлэлийн тухай лавлагаа
- МҮНС-гийн уламжлалт болон электрон номзүйн нөөцүүдийг, мөн түүнчлэн интернет сүлжээ ашиглан гүйцэтгэх боломжтой сэдэвчилсэн лавлагаа
- Баримтын тодотгосон лавлагаа

4. Үйлчилгээ

Хэрэглэгчдэд лавлагaa өгөхдөө:

- Мэдээллийг бие даан олж авахад зориулан интернет сүлжээн дэх мэдээллийн эх сурвалжийн хаягийг зааж өгөх,
- Номзүйн бэлэн хариултыг өгөх, /20 хүртэлх номзүйн бичилттэй/
- Өгөгдсөн лавлагааны суурь бааз /архив/-аас мэдээллээ бие даан хайх боломжтой байх

5. Үйлчилгээний нөөц бааз

- Номын сангийн лавлагаа-номзүйн аппарат /Уламжлалт болон электрон каталог, картын сан, өгөгдсөн лавлагааны архив, лавлагааны фонд/, интернет нөөц, бусад зөвшөөрөгдсөн дижитал эх сурвалжууд
- Тус албанд өгөгдсөн лавлагааны архив

6. Ерөнхий хязгаарлалт

Доорх чиглэлээр үйлчилгээний хязгаарлалтыг хийнэ. Үүнд:

- Зугаа цэнгэлийн шинж чанартай лавлагаа (үгийн сүлжээ таах, оюуны тоглоом болон бусад уралдаан)
- Байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой лавлагаа
- Зөвшөөрөгдөөгүй баримтын скайнердсан хуулбар
- ВЛА-нд сурталчилгааны шинж чанартай мэдээлэл тавьж болохгүй

7. Албаны ажлын хуваарь

- Лавлагааг ажлын өдрүүдэд хүлээн авч, зохих журмын дагуу гүйцэтгэнэ.
- Амралтын өдөр лавлагаанд хариулт өгөхгүй